



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2019 оны 11 сарын 22 өдөр

Дугаар А/714

Арвайхээр

Цэцэрлэг шинээр байгуулах, нэршил  
өөрчлөх тухай


Боловсролын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.3, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын дэргэдэх Боловсрол, соёл, урлагийн газрын 2019 оны 314 дүгээр албан бичгээр ирүүлсэн дүгнэлтийн дагуу Уянга суманд шинээр баригдсан 100 хүүхдийн хүчин чадалтай цэцэрлэгийг 2 дугаар цэцэрлэгээр үүсгэн байгуулсугай.

2. Тус сумын 2 дугаар цэцэрлэг шинээр үүсгэн байгуулагдаж байгаатай холбогдуулан Уянга сумын цэцэрлэгийн нэршлийг Уянга сумын 1 дүгээр цэцэрлэг болгон өөрчилсүгэй.

3. Уянга сумын 2 дугаар цэцэрлэгийн үйл ажиллагааны дүрэм, бүтэц, зохион байгуулалтыг 2019 оны 12 дугаар сарын 15-ны дотор хийж, сургалтын үйл ажиллагааг зохион байгуулах бэлтгэл ажлыг ханган, тусгай зөвшөөрөл авахад шаардагдах материалыг хуулийн дагуу бүрдүүлэхийг аймгийн Засаг даргын дэргэдэх Боловсрол, соёл, урлагийн газар (Ж.Пүрэвсүрэн), Уянга сумын Засаг дарга (Б.Доржтогоо)-д тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ГАНБОЛД

011101355